

МАХАТМА ГАНДИЙН ҮЗЭЛ САНАА ОРЧИН ҮЕ БОЛОН ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНД ХОЛБОГДОХ НЬ

Д. Цолмон¹

Эрхэм хүндэт зочид оо,
БНЭУ-ын Элчин сайд эрхэмсэг ноён Ёгишвар Варна,

Өнөөдөр Х сарын 2-нд Энэтхэгийн ард түмний оюун санааны их багштан Махатма Гандийн мэндэлсний ойг МУИС-ийн ОУХС-ийн багш, оюутнууд БНЭУ-ын ЭСЯ, хоёр орны найрамдлын нийгэмлэг, Энэтхэгийн соёлын төвтэй хамтран ёслон тэмдэглэж эрдэм шинжилгээний хурал зохиож байгааг сургалт судалгааны хувьд бас хоёр орны ард түмний бие биеэ гүнзгий танин мэдэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ гэж бодож байна.

Энэтхэгийн ард түмнийг Британий эзэнт гүрний колоничлолоос ангижруулж, тусгаар тогтнолоо байлдан олох ариун үйлст түүний гүйцэтгэсэн үүргийг, бас гүн сэтгэгч, нигүүлсэнгүй үзэлтэн, интернационалч, улс төрийн стратегич тэр агуу их хүний тухай өнөөдрийн өндөрлөгөөс дүгнэн ярихад амаргүй гэдэг нь ойлгомжтой.

Монгол улсыг олон үндэстний их чуулга НҮБ-д элсэхэд нааштай нөлөөлж манай хоёр ард түмний түүх, соёлын уламжлалт харилцааг хөгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргасан Энэтхэг улсын анхны Ерөнхий сайд асан, улс төр, нийгмийн томоохон зүтгэлтэн Жавхарлал Неру нэгэнтээ Гандийг бишрэн хүндэтгэж хамтран зүтгэж явсан хүний хувьд өгүүлэхдээ: “Гандийн намтрыг бичнэ гэдэг үнэндээ амаргүй. Хагас зуун жил, түүнээс ч илүү хугацаанд түүний амьдрал тэмцэл, Энэтхэгийн ард түмний амьдралтай салшгүй холбоотой учраас үнэнхүү ярвигтай юм. Гандийн тухай бичих оролдлого олонтаа гарч байна. Гэхдээ түүний амьдрал тэмцлийг юутай ч зүйрлэшгүй үйл ажиллагааны нь зарим талыг тодруулан авч үзвээс Энэтхэгийн ард түмний үл мартагдах үеийг бусад хүмүүст зохих хэмжээний ойлголт өгөхөд ач тустай, амжилттай болно” гэж өгүүлсэн нь үндэстэй юм².

1869 онд Баруун Энэтхэгийн Парбандерт мэндэлж яваандаа бага насандаа бэрхшээлт амьдралыг туулан эзэн гүрэнд өмгөөлөгчийн боловсрол эзэмшээд хэнд ч үл анзаарагдах энгийн залуугийн оюун ухаанд ирээдүйн их сэтгэгч, үнэний төлөө тууштай тэмцэх үзэл бүрэлдэн төлөвшчээ. Газар нутаг, хүн амаараа дэлхийд дээгүүр ордог энэ улсын уудам нутгийг бүхэлд нь хөндлөн гулд явганаар туулж нийгмийн янз бүрийн давхрагын хүмүүсийн амьдрал, хэл, ёс заншлыг гүнзгий судалсан тэр хүнтэй хэнийг зүйрлэх вэ? Өнөөдрийн энэ арга хэмжээний сэдвийг ч Махатма Гандийн үзэл санаа өнөөдөр хэрэгтэй юу хэмээн томъёолж байгааг эргэцүүлэн суухад энэ асуулт өөрөө ярвигтай бас харьцангуй ойлголт, хариулт шаардана гэж бодном.

Хинди, урду, тамил, гуджарат, телугу, бенгал хийгээд англиар хэнтэй л бол хэнтэй ярьж чаддаг байсныг нь олон судлаач, түүхчид тэмдэглэн үлдээжээ. Тэрээр алдар цол, албан тушаал

¹ МУИС, ОУХС-ийн тэргүүлэх профессор, доктор (Ph.D).

² Jawaharlal Nehru, Glimpses of World History, London, 1949

гуншинг, эрх мэдлийг үл хүсэгч агуу хүн байсныг гэрчлэх баримтыг олонтаа уншин биширч байлаа. Дээдсийн тансаг амьдрал, зугаа цэнгэл, өнгө мөнгөнөөс ангид хамгийн энгийн даруу мөртөө, оюуны өндөр чадавхиар олноос тодрон гарчээ.

Жинхэнэ удирдагч хүн олон түмний дунд орж, тэдний зовлон жаргалыг үгээр бус, үйл хэргээрээ хуваалцаж явах ёстойг тэр биеэрээ үлгэрлэн харуулж, бас тэднийг сонсч, тэднээс суралцаж хөдөлмөрлөж байхын үлгэр дууриал бол Гандийн амьдрал гэж хэлэхэд болно. Ер нь хүн ардынхаа дундаас л чөлөөлөгчид, соён гэгээрүүлэгчид төрсөн байдаг нь өсч торнисон хөрс шороо, хүрээлэн буй орчин, нийгэмтэй холбоотой юм. Энэ агуу хүний үзэл баримтлал нь Энэтхэгийн гүн ухаан, улс төрийн сэтгэлгээний арвин уламжлалын илэрхийлэл юм.

Гандийн сургаал номлолыг бүхэлд нь дагахыг, түүнийг бүхий л талаар зөвтгөх, эсвэл эсэргүүцэхэд бус хүний нийгэм ямагт өөрчлөгдөн өөр өөр хэв ёс, үзэл бодол, үндэсний онцлогийг харьцангуйн үүднээс авч үзэх нь мэдээж хэрэг ээ. Ангийн тэмцлийн онолоор хүмүүжсэн марксистууд түүний үзлийг шинжлэх ухаанд харш, идеалист, үл гүйцэлдэх үзэл гэж шүүмжилж байжээ.

1978 онд Махатма Гандийн “Миний намтар” бүтээлийг нь монгол хэлнээ манай нэрт яруу найрагч М.Цэдэндорж, эрдэмтэн Г.Сүхбаатар нар орчуулан олны хүртээл болгосныг уншсанаа эдүгээ эргэн санаж байна.

Ядуутар амьдрал, хийсэн гэмээ төв шудрагаар хүлээж эцэгтээ хүлцэл өчсөнийг, бүрэг зангаа орхих, англи ёсоор соёлтой амьдрах, олны өмнө үг хэлж сурах, Лондонд Английн амьдралтай танилцаж, Парисыг үзэж нүдээ нээж, өмгөөлөгч болсон түүхээсээ өгүүлээд, арьс өнгөөр гадуурхагдаж, өвдөж, шоронд орж зовж явснаа нүдэнд харагдтал дүрсэлсэн байдаг билээ. Тэрээр амьдрал тэмцлийнхээ алдаа оноог шударгаар хүлээн зөвшөөрч нягт эрэгцүүлэн бясалгаж, улс төр судлалыг тусгайлан судлаагүй ч нөр их хөдөлмөрийн үр дүнд улс төрийн стратегич, тэмцэгч болсон ажээ.

Ганди интернационалч хүн байжээ.

Өөрийнхөө амьдралын тухай “миний бүхий л амьдрал, үйл ажиллагаа бол хүн төрөлхтнийг энэрэн хайрлахад зориулагдсан юм” гэжээ. Ганди Энэтхэг үндэстэндээ хайрлагддаг боловч үндэсний явцуу үзлийг номлоогүй. Хүн төрөлхтний нийтийн ашиг сонирхлыг үндэсний ашиг сонирхлоос дээгүүр тавьж байсан ажээ. Олон улсын асуудлууд, улс хоорондын харилцаанд хандахдаа хүн төрөлхтний нийтлэг ёс суртахуун, шударга ёсыг удирдлага болгохыг чухалчилж үзэж байв. “Үндэсний үзлийг би ойлгохдоо миний эх орон эрх чөлөөгөө олж авахдаа хэрэв хүн төрөлхтөн амьд оршиход шаардлагатай бол бид үхэхэд бэлэн байх учиртай гээд эх оронч үзэл ертөнцийн хүн зоны сайн сайханд үйлчлэх учиртай. Дэлхийн улс үндэстнүүдийн зорилго бол салангид тусгаар тогтнол бус сайн дурын нааштай харилцан хамаарал, ертөнцийн янз бүрийн үндэстнүүдийн соёлоор баяжсан бүх соёл иргэншлийн тусын тулд нягт бөгөөд найрсан хамтын ажиллагаа чухал” гэж үзэж байлаа. Хэрэв энэ үзлийг орчин үетэй холбож авч үзвээс даяарших үйл явцыг урьдчилан томьёолсон агуулгатай нийцэж байгаа юм. Өөрөөр хэлбэл Гандиджи буюу энэхүү ухаантан дэлхийн хэмжээнд сэтгэж чаддаг байсны нотолгоо мөн.

Сатьяграха бол Энэтхэгийн ард түмний тусгаар тогтнол, эрх чөлөөний тэмцлийн нэг хэлбэр байлаа.

Гандийн боловсруулан дэвшүүлсэн “сатьяграха” буюу хүч хэрэглэхгүйгээр үнэний төлөө тууштай тэмцэх үзэл санаа Энэтхэгийн ард түмний улс төрийн сэтгэлгээнд шингэсэн шинэ номлол болжээ.

Британий империализмын дарлалаас улс үндэстнээ цэрэг зэвсгийн хүчээр бус олон янзын арга, тухайлбал Энэтхэгт английн засгийн газрын үйл ажиллагаа, худалдааг бойкотлох, эрх баригчидтай улс төрийн талаар хамтарч ажиллахгүй байх, иргэд Английн захиргаа, хууль ёсонд захирагдахгүйгээр саад тогтор учруулах, ажил хаях зэрэг олон түмнийг хамарсан томоохон арга хэрэгсэл ашиглан жагсаал цуглаанд үг хэлж ард олны дэмжлэг авч чаджээ. Үнэхээр бүрэн

зэвсэглэсэн Английн армийн эсрэг гартаа барих зэвсэггүй олон түмнийг босговоос сүйрэлд хүрнэ гэдгийг Ганди гүнзгий ухамсарлаж байжээ.

Хүч үл хэрэглэх (ахимса) түүний номлол радикал, экстремист үзэлтнүүд, түүний дотор Английн улс төрчдийн ширүүн эсэргүүцэлтэй тулгарч байжээ. Жавхарлал Неру эрх чөлөөг яаж байлдан олох тухай өгүүлэхдээ зөвхөн эсэргүүцэл, шаардлага үр дүн муутай гээд ийм арга хэрэгслүүдийг ашиглаад ноёрхогч анги эрх мэдлээсээ сайн дураараа татгалзаж амжилтанд хүрч байсан түүх байхгүй. Харин ч дарлагдсан ард түмэн, ангиуд эрх чөлөөгөө хүч хэрэглэсэн бослого хөдөлгөөнөөр олж авч байсныг түүх гэрчилдэг. Гэхдээ Энэтхэгийн ард түмний тухайд зэвсэгт бослого гаргах боломжгүй байв. Бидэнд зэвсэг байсангүй, бидний ихэнх нь уг зэвсгийг яаж хэрэглэхээ мэдэхгүй байсан гэж Махатма Гандийн үзэл бодлыг дэмжжээ³.

Гандийн үзэл санаа олон түмэнд хүчтэй нөлөөлж иргэний ухамсар, өөртөө итгэх итгэлийг бүрэлдүүлж өгсөнд түүний бас нэгэн гавьяа, улс төрийн ач холбогдол оршино гэж бодож байна.

1929 онд сатьяграхийн 2 дахь том амжилт нь Британий засаг захиргаа давсны хууль гаргахад түүнийг эсэргүүцэн тээвэрлэж ирсэн давсыг нь далайд асгаж энэтхэгчүүд гар аргаар давс олзворлож, Английн худалдаа, банк бүхэлдээ зогсох аюулд хүрчээ. 1930 оны 3-р сард Ганди давсны харгис хуулийн эсрэг алдарт жагсаалаа зохион байгуулсан бөгөөд Ахмедабад хотоос Данди хот хүртэл 400 км газрыг туулсан энэхүү жагсаалд олон зуун мянган энэтхэгчүүд оролцсон бөгөөд Британий Засгийн газар 60 000 хүнийг баривчлан хорив.

Жилийн дараа Лорд Ирвиний Засгийн газар Махатма Гандитай хэлэлцээ хийж эсэргүүцлийн хөдөлгөөнийг зогсоосон тохиолдолд бүх улс төрийн хоригдлуудыг суллахаар амлав. Энэ бол том амжилт байжээ.

Иймэрхүү аргыг Английн эзэнт гүрнээс салан тусгаарлахын төлөө эрчимтэй тэмцэж байсан Америкийн хувьсгалчид Sugar Act, Tea Act зэрэг хуулиудыг эсэргүүцэн амжилт олж байсан түүхтэй юм. 1773 оны 5-р сард Британий засгийн газраас гарсан “Цайны хууль”-д цайг зөвхөн Английн Ост Индиа компанийн усан онгоцоор тээвэрлэх, ямар нэгэн татвар ноогдуулахгүй байхаар заасан байдаг. “Эрх чөлөөний хөвгүүд” бүлгийн зүсээ хувирган индиан маягаар хувцасласан 150 залуус мөн оны 12-р сарын 16-нд цай тээвэрлэж ирсэн усан онгоцонд нэвтэрч 342 авдар цайг далайд асгаж түмэн фаундын хохирол учруулсан ажээ⁴.

Махатма Гандийн Энэтхэгийн нийгмийн хамгийн доод давхарга болох шоовдорлогдсон хүмүүсийн эрхийн төлөө тууштай тэмцэж байсан бөгөөд тэднийг “харижан” буюу “Бурханы хүүхдүүд” хэмээн дотночлон нэрлэж байв. 1933 оны 5-р сард Ганди харижаны хөдөлгөөнийг дэмжиж 21 хоног өөрийгөө ариусгах мацаг барьж байв.

Дэлхийн 2-р дайны үед Энэтхэгийн тусгаар тогтнолын төлөөх хөдөлгөөн улам өргөжиж, британичуудыг Энэтхэгээс зайлахыг эрчимтэй шаардах болов. Энэтхэгээс зайл хэмээх энэхүү хөдөлгөөн тусгаар тогтнолын төлөө тэмцлийн хамгийн хүчтэй илэрхийлэл болсон бөгөөд олон мянган энэтхэгчүүдийг баримвчлагдаж, олон хүн бууны суманд өртөн амь насаа алдсан юм. Ганди хэрэв Энэтхэгт нэн даруй тусгаар тогтнол олгохгүй бол холбоотнуудыг дайнд дэмжихгүй гэдгээ илэрхийлж байв. 1942 оны 8-р сарын 9-нд Махатма Ганди болон Үндэсний Конгресс намын бүх удирдлагыг баривчилж, Гандиг Пүн хот дахь Ага Ханы ордонд гэрийн хорионд 2 жил суулгав. Хумхаа өвчин тусаж, эрүүл мэнд нь доройтсон Гандиг 1944 оны 8-р сарын 6-нд сулласан байдаг. Түүнийг хорионд байлгаж үхүүлж, ард түмний хилэнг бадраахгүй гэсэн хэрэг байв.

Дэлхийн II дайны төгсгөл ойртохын хэрээр британичууд засгийн эрхийг энэтхэгчүүдийн гарт шилжүүлэх талаар ил тод мэдэгдэж эхэлсэн бөгөөд үүнтэй холбогдуулж Ганди нутаг нэгтнүүддээ хандан тэмцлээ зогсоохыг уриалсан бөгөөд 100 000 гаруй улс төрийн хоригдол, түүний дотор Үндсэний Конгрессын удирдлагууд суллагджээ.

Махатма Ганди Энэтхэгийг хуваах аливаа оролдлогын эсрэг шийдвэртэй тэмцэж байсан бөгөөд лалын болон хиндү шашинтны хооронд гарч байсан хүчирхийллийг эсэргүүцэж

³ Jawaharlal Nehru, *Glimpses of World History*, London, 1949

⁴ Д.Цолмон, АНУ-ын түүх, УБ, 2007, 84 дэх тал

өлсгөлөн зарлаж байв. Энэтхэг улс хуваагдахаас нэг жилийн өмнө “Энэтхэгийг хуваахаасаа өмнө миний биеийг хоёр хэсэг болгон огтол” гэж мэдэгдэж байв.

Махатма Ганди 1948 оны 1-р сарын 30-нд Дели хотын Бирла Баваны ойролцоо хиндү шашны радикал үзэлтний бууны суманд өртөн харамсалтайгаар амь насаа алдсан нь Энэтхэгийн ард түмэнд хүнд гарз болсон билээ. Гэвч түүний үзэл санааны өв уламжлал мартагдаагүй явсаар өдий хүрчээ.

Гандийн үзэл санаа тэмцлийн арга хэрэгсэл Энэтхэгийн хил хязгаараас давж олон үндэстний сонирхлыг татах болсныг гэрчлэх баримт олон бий. Америкийн хар арьстнууд эрх чөлөөний тэмцэлдээ түүнээс санаа авсан байдаг. 1937 онд доктор Charming Mobias, Dr. Benjamin Mays нар Гандитай уулзахаар Энэтхэгт ирж зөвлөгөөг нь авч байсан бол “Дэлхийн бусад хэсэгт энэхүү зоригжуулагч үзэл санаа дэлгэрч социалист орнуудад нацистуудын эсрэг маш хүнд нөхцөлд” тоталитар дэглэмийг халах хөдөлгөөнд ийм арга хэрэгсэл нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг.⁵

Махатма Гандийн улс төрийн тэмцлийн, ялангуяа хүч үл хэрэглэх, хүчээр түрээ барих явдлыг олон улсын эрх зүй хүлээн зөвшөөрдгийн нэг бодит жишээ бол НҮБ-ын дүрэмд заасан олон улсын аюулгүй байдлыг сахин хамгаалах, олон улсын харилцааны түгээмэл зарчмуудтай уялдаж байгаа юм. БНЭУ-ын нэрт улс төрч Жавхарлал Неругийн идэвхтэй оролцоотой өрнөсөн Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн ч, мөн улс хоорондын харилцаанд энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчим буюу Панча Шиллаг боловсруулахад Неругийн хувь нэмэр их байсныг энд бүгд мэднэ. Өргөн утгаараа Гандийн үзэл санааны өв уламжлалтай энэ асуудал холбогдоно гэж бодож байна.

Өнөөгийн олон улсын харилцаа хийгээд, улс түмний аюулгүй байдалд аюул занал учруулж байгаа терроризмыг Ганди хурцаар шүүмжилж байсан билээ. Үнэндээ терроризм ганц нэг улсыг бус дэлхий нийтийг доргиож байна.

Ганди ердийн пасифист буюу хүлцэнгүй нэгэн бус харин нэн идэвхтэй агуу тэмцэгч байсныг цохон тэмдэглэхэд илүүдэхгүй. Англи-бурын дайнд оролцож аврах ажиллагаа зохион байгуулж, дэлхийн янз бүрийн шашин номын төлөөлөгчдөөс аваад лордууд, хаад, фашистуудтай (Муссолини) хүртэл уулзаж ном хаялцаж Английн эрх баригчидтай дугай ширээний хэлэлцээнд Үндэсний Конгресс нам, эх орончдоо төлөөлөн оролцож явсан нэртэй улс төр, нийгмийн зүтгэлтэн байлаа.

Түүнийг үл томсорлосон хүмүүс ч өрнөдөд олон байжээ. Английн Консерватив намын дарга Ерөнхий сайд асан Уйнстон Черчилль Гандийг “хагас нүцгэн бадарчин” гэж хочлосонд Неру хариу болгож Гандийг доромжлох нь энэтхэгчүүдийг доромжилж ойлгохгүй байгаа явдал гэж тэмдэглэсэн байдаг.

Янз бүрийн шашныг хүндэтгэж, шашин хоорондын (лал, индус) зөрчлийг эвлэрүүлэн зогсоох, бие хүний шүтэх бишрэх эрх чөлөөг хүндэтгэж байжээ. “Хэрэв би дарангуйлагч байсан бол шашин, төрийг тусгаарлах болно” гэсэн түүний мэргэн үг өнөөгийн Монголд ч сургамжтай гэж би боддог.

Нэрт зохиолч Раскины бүтээлийг уншиж шимтэн түүнээс сарванйядайд үзлийн санааг олж авсан тухай түүний намтарт байдаг юм⁶. Ялангуяа 1904 оноос өөрийн гаргаж байсан “Индиан опинион” сэтгүүлдээ шинжлэх ухаан, оюуны хөдөлмөрийн хүмүүс биеийн хөдөлмөр эрхэлж байхын чухлыг олон түмэнд ухааруулжээ. Энэ утгаараа Оросын нэрт зохиолч Л.Толстойтой санал нэгдэж байжээ. Ер нь хөдөлмөрийн хүмүүжил хүн болж төлөвших гол шижим гэж олон сурган хүмүүжүүлэгч бас олон түмэн үзсээр ирсэн юм.

Махатма “нийтээрээ сайхан баймааж нэг хүн сайхан байна” гэдэг зарчмыг баримтлах болсноо “Миний намтар” бүтээлдээ тусгасан байдаг. Гандид өгөх үнэлэлт энэхэн үед хангалттай бус, ялангуяа хувьсгалч байсан уу, үгүй юу? олон улсын харилцаанд их гүрнүүд

⁵ Gandhi, His Relevance For Our Time by Gene Sharp, http://www.mrgandhi.org/g_relevance/chap10.html, 09.26.2008

⁶ M.K.Gandhi, An autobiography or the Story of my experiments with Truth, Navajivan Trust, 1927, 2002 (the magic spell of a book unto this last)

хүч үл хэрэглэх зарчмыг хэрэгжүүлж байна уу, үгүй юу? гэдэг нь маргаантай байдаг. Үнэндээ нийгмийн сэтгэлгээг өөрчилж олон хүнийг араасаа дагуулсан түүний тэмцлийг хувьсгалч бус гэж үзэх үү?

Өрнөдийн соёл иргэншил, сэтгэлгээ, амьдралын хэв маяг азийнхнаас ялгаатай. Гэхдээ монгол хүнд Гандийн үзэл санаа илүү ойр дөт, ойлгомжтой байгаад гайхах зүйлгүй. Түүний намуухан дуу хоолой уран илтгэгчдээс илүү сонсогдож, найз нөхөд, сөрөг хүчний зүрхэнд хүрч Энэтхэгийн ард түмний тэмцлийн бэлэг тэмдэг болон үлдсэнээр барахгүй дэлхийн гүн ухаантнууд, жинхэнэ уран бүтээлч зохиолчид тухайлбал, Рабиндрат Тагор, Бернард Шоу, Лев Толстой, Ромен Роллан хүндэтгэж биширч байжээ.

“Магадгүй, өсвөр үеийхэн ердийн яс махан бодитой ийм нэгэн хүн энэ ертөнцөд алхаж байсанд итгэх болов уу, үгүй болов уу?” гэж харьцангуйн онолын эцэг суут эрдэмтэн Алберт Эйнштейн өгүүлсэн байдаг нь учиртай гэдгийг дурдая.